



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2000 оны 8 дугаар
сарын 11 өдөр

Дугаар 260

Улаанбаатар хот

**"Улаанбаатар Зам засвар" компаний
талвар авах арга хэмжээний тухай**

Монгол улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дугаар заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2000 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 47 тоот тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Зам, гэрэл дохионы байгууллагуудад бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийсэнтэй холбогдуулан "Улаанбаатар Зам засвар" компаний дүрмийг хавсралт № 1-ээр шинэчлэн баталсугай.

Хоёр. "Улаанбаатар Зам засвар" компани /Д.Отгонсүрэн/ нд **ДААЛГАХ НЬ:**

а/ Авто зам барилгын "Улаанбаатар" компани, Дохио үйлдвэрээс "Улаанбаатар Зам засвар" компанид шилжин ирж байгаа байшин барилга, техник тоног төхөөрөмж, эд хөгшлөөс дутагдсан хөрөнгийн асуудлыг хуулийн байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

б/ Хэрэгцээ шаардлага хангахгүй болсон техник тоног төхөөрөмж, эд хөгшлыг актлаж устгах асуудлыг боловсруулж Нийслэлийн Өмчийн газраар шийдвэрлүүлэх.

Гурав. Энэ захирамжийн 2 дугаар хавсралтад дурьдсан үндсэн хөрөнгө болох байшин барилга, авто машин механизм, тоног төхөөрөмж борлуулах, хавсралтанд дурьдсан өр авлагыг барагдуулах асуудлыг боловсруулж Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн Хуралд оруулж шийдвэрлүүлэхийг Нийслэлийн Өмчийн газар /Б.Буюнмөнх/-д даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД

Нийслэлийн Засаг Даргын
2000 оны 260 Тоот
захирамжийн хавсралт №1

"Улаанбаатар Зам Засвар" Компани Нийслэлийн Өмчит
Үйлдвэрийн Газар /НӨ ҮГ/-ийн
ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Компаний оноосон нэр:
 - а/ Бүрэн нэр: "Улаанбаатар Зам Засвар" НӨ ҮГ
 - б/ Товчилсон нэр: "УБЗЗ" НӨ ҮГ
 - в/ Компаний оноосон нэр англиар "UB Road Renovation" Co.LTD
2. Компаний хаяг:
 - а/ Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 16 дугаар хороо
"С Дэнзэнгийн гудамж"
 - б/ Шуудангийн хаяг:
 - в/ Харилцах утасны дугаар" 453363, 54847
3. Компаний үүсгэн байгуулагч:
"Улаанбаатар Зам Засвар" НӨ ҮГ-ын үүсгэн байгуулагч нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний эрх олгосноор Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч байна.
4. "Улаанбаатар" НӨ ҮГ нь бие даасан тайлан тэнцэлтэй, банкинд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээх хуулийн этгээд. Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар хэлбэрээр ажиллана.
"Улаанбаатар Зам Засвар" НӨ ҮГ нь үйл ажиллагаагаа дараахь чиглэлээр явуулна.
 - Улаанбаатар хотын авто замын угсралт, засварын ажлыг хийх
 - Улаанбаатар хотын замын гэрэл дохио, тэмдэг, тэмдэглэгээ, бродюр, түмбэ, шон, лентэн брусс зэргийг угсрах, засварлах
 - Хот тохижилтын байгууламж, явган хүний зам, хүүхдийн тоглоомын талбай, автомашины зогсоол зэрэг бусад байгууламжийг барьж байгуулах
 - Дээрхи үйл ажиллагаа болон үйлдвэрлэл үйлчилгээ явуулах зорилгоор гадаад, дотоод худалдаа эрхлэх
 - Байгууллагын ажиллагсдын хэрэгцээнд зориулан туслах аж ахуй эрхлэх
5. Компаний үйл ажиллагаа явуулах хугацаа:
"Улаанбаатар Зам Засвар" НӨ ҮГ нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.
6. "Улаанбаатар Зам Засвар" НӨ ҮГ нь өөрийн салбар, эсвэл тогослогчийн газрыг Нийслэлийн Засаг Даргын шийдвэрээр ажиллуулж болох бөгөөд үүнийгээ хуульд заасан хугацаанд улсын бүртгэлд бүртгүүлнэ.
7. "Улаанбаатар Зам Засвар" НӨ ҮГ нь дүрэмд орсон өөрчлөлтүүдээ хуульд заасан хугацаанд улсын бүртгэлд бүртгүүлнэ.
8. Компани нь улсын бүртгэлийн гэрчилгээ авсан өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулна.

Хоёр. Компанийг үүсгэн байгуулагчийн эрх үүрэг

1. Компанийг татан буулгах, өөрчлөн зохион байгуулах, асуудлыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал зохих хуулийн дагуу шийдвэрлэнэ.
2. Компанийг үндсэн чиг үүргийг нь өөрчлөхгүйгээр бусад хэлбэрээр өөрчлөн зохион байгуулах, дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг Нийслэлийн Засаг дарга шийдвэрлэнэ.
3. Компаний захирлыг Нийслэлийн Засаг Дарга томилж ажиллуулна.
4. Компанийг удирдуулахаар "Нийслэлийн Өмчит Үйлдвэрийн Газрын захиралтай байгуулах хөдөлмөрийн гэрээ" г Нийслэлийн Өмчийн Газар Компаний захиралтай байгуулж, жил бүр дүгнэж ажиллана.

Гурав. Компаний үндсэн эрх

1. Компани нь өөртөө барааны тэмдэг болон бэлэгдэл /эмблем/, албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэг /гамга/ хэрэглэнэ.
2. Компани өөрийн үйл ажиллагаагаа бие даасан байдлаар эсвэл бусадтай хамтран монгол улсын хуулийн хүрээнд эрхлэн ялуулна.
3. Компани өөрийн үйл ажиллагаагаа өргөтгөх, Үйлчлүүлэгчид болон зах зээлдээ ойртох гэх мэт зорилгоор улс дотроо болон гадаадад салбар төлөөлөгчийн газар ажиллуулж болно.
4. Компаний үндсэн болон туслах үйлдвэрлэл үйлчилгээний ажлыг хэвийн явуулах зорилгоор мэргэжил, чадвар сайтай, дадлага туршлагатай хүмүүсийг хөдөлмөрийн гэрээгээр авч ажиллуулах, тэдний ажиллах нөхцөл, цалин хөлс, урамшууллын хэмжээг Нийслэлийн Өмчийн Газраас батласан хэмжээнд багтаан тогтооно.
5. Компани өөрийн үйл ажиллагаатай холбогдох зарим мэдээллийг хуулийн дагуу нууцлана.
6. Компаний үйл ажиллагааг хэвийн явуулахтай холбогдох мэдээлэл цуглуулах, мөн ийм мэдээллийг үйлчлүүлэгч сонирхогчдод хүргэнэ.

Дөрөв. Компаний үндсэн үүрэг

1. Компани нь энэхүү дүрмийн 1-ийн 4-т заасан үйл ажиллагааг монгол улсын хуулийн дагуу эрхлэх үүрэгтэй.
2. Компани нь Монгол Улсын "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хууль, "Аудитын тухай" хуулийн дагуу нягтлан бодохын болон анхан шатны дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөн санхүүгийн тайлан тэнцэл гарган баталгаажуулна.
3. Компани хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын өмнө хуулиар өгөгдсөн үүргүүдийг биелүүлнэ.
4. Үндсэн хөрөнгөнд хамаарах эд хөрөнгө олж авах, бэлтгэх, устгах, өөрчлөх, бусдад худалдах шилжүүлэх, эзэмшүүлэх зэрэг үндсэн хөрөнгийн хөдөлгөөнтэй холбогдох бусад үйл ажиллагааг явуулахдаа энэ тухай асуудлаа Нийслэлийн Өмчийн Газарг албан ёсоор тавьж шийдвэрлүүлнэ.

5. Компани нь жил бүр бизнес төлөвлөгөөгөө Өмчийн Газраар батлуулан тайлагнаж ажиллах бөгөөд Санхүүгийн тэнцэл, үйл ажиллагааныхаа тайланг бүтэн, хагас жил тутамд Өмчийн газарт ирүүлнэ.
6. Компани нь үйл ажиллагааныхаа үр дүнд олсон ашгаас эрх бүхий байгууллагын тогтоосон хувь хэмжээгээр ногдол ашгийг зохих журмын дагуу өөрийн харьцдаг дүүргийн төсөвт төвлөрүүлнэ.
7. Компани нь энэхүү дүрмийн 1-4 -д заасан шилжлийн үйл ажиллагааг явуулахдаа эхний ээлжинд Нийслэл Улаанбаатар хотын захиалгат ажлыг гүйцэтгэх бөгөөд гагцхүү хуулийн хүчин төгөлдөр гэрээ, холбогдох шийдвэрийн үндсэн дээр гүйцэтгэнэ.

Тав. Компаний үндсэн хариуцлага

1. Компани нь зөвхөн өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээнэ.
2. Компаний захирал, нягтлан бодогч нар нь эрх бүхий албан тушаалтан байх хугацаандаа өөрийн хууль бус үйл ажиллагаанаас учирсан хохирлыг хариуцна.
3. Монгол Улсын хуульд заасан бусад хариуцлагыг хүлээнэ.

Зургаа. Компаний хөрөнгө

1. Компаний өөрийн хөрөнгө буюу дүрмийн сан нь 398.8 сая төгрөгийн үл хөдлөх ба хөдлөх хөрөнгө, 4.1 сая төгрөгийн үндэсний мөнгөн тэмдэгтээс бүрдсэн нийт 402.9 сая төгрөгийн хөрөнгөтэй байна.
2. Компани нь өөрийн хуримтлагдсан ашгаар дүрмийн сангаа нэмэгдүүлж болно.
3. Швардлагатай бол дүрмийн санд шинээр хөрөнгө оруулна.
4. Компаний хөрөнгийг захиран зарцуулах эзэмших, ашиглахдаа "Гөрийн болон орон нутгийн Өмчийн тухай" хуулийн дагуу шийдвэрлэнэ.
5. Компаний үүсгэн байгуулагч буюу Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь компаний үйл ажиллагааны цэвэр ашгийг хуульд өрөөр заагаагүй бол бүрэн захиран зарцуулна.

Долоо. Компаний удирдлага, түүний эрх хэмжээ

1. Компаний захирлыг Нийслэлийн Засаг Даргын захирамжаар томилно.
2. Захирлын эрх, үүрэг хариуцлага, цалин хөлс, урамшуулал болон бусад харилцааг "Нийслэлийн өмчит Үйлдвэрийн Газрын захиралтай байгуулах хөдөлмөрийн гэрээгээр зохицуулах бөгөөд энэхүү гэрээг Өмчийн Газар Нийслэл ийн Засаг Даргын нэрийн өмнөөс байгуулна.
3. Компаний захирал нь Санхүүгийн болон үйл ажиллагааныхаа тайлан, балансыг хагас жил болон жилийн эцэст гаргаж, гэрээний биелэлтийн талаар Өмчийн газрын өмнө тайлагнана.
4. Захирал нь компанийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах болон хариуцагчийн үүрэг хүлээнэ.
5. Компаний захирал нь удирдах дээд байгууллагатай зөвшилцөж, компаний ерөнхий нягтлан бодогчийг томилно.

Найм. Компаний санхүүгийн тайлан, хяналт шалгалт

1. Компани нь Санхүүгийн тайлангаа "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хууль, "Аудитын тухай" хуулийн дагуу баталгаажуулан үүний үндсэн дээр холбогдох хуулийн заалтад нийцүүлэн тогтоосон хугацаанд нь татварын тайлан гаргаж тооцоо хийнэ.
2. Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, балансыг хатас жил тутамд гаргаж Нийслэлийн Өмчийн Газар болон бусад холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгнө.
3. Санхүүгийн тайланд дараахь бүрдэл хэсгүүдийг заавал оруулна.
 - Баланс
 - Орлого үр дүнгийн тайлан
 - Мөнгөн гүйцээний тайлан
 - Хуримтлагдсан ашгийн тайлан
 - Тайлангийн тайлбар тодруулга
 - Тайлангийн илтгэх хуудас
 -
4. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг захирал хариуцна. Компаний орон тоонд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж, байгаа өрөнхий нягтлан бодогч энэхүү хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.
5. Санхүү аж ахуйн үйл ажиллагаа, ня-бо бүртгэл, тайлан тэнцэл, татварын тооцооллын үнэн магадад хөндлөнгийн байгууллагаар шалгалт хийлгэж, ажил сайжруулах тусалцаа авч байна.
6. Хяналт шалгалт, лавлагаа, түүх архивын зорилгоор дараахь баримт бичгүүдийг хуульд заасан хугацаагаар хадгална.
 - Компаний дүрэм, түүнд орсон өөрчлөлтүүд
 - Компаний улсын бүртгэлийн гэрчилгээ
 - Компаний дотоод бичиг баримт материалууд
 - Нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт бичгүүд
 - Компаний удирдлагын тушаал шийдвэр, хурал зөвлөлгөөний тэмдэглэлүүд
 - Санхүү, аж ахуйн үйл ажиллагааны анхан шатны болон дэлгэрэнгүй бүртгэл, ня-бо бүртгэлийн баримт бичиг материалууд
 - Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцэл түүнд холбогдох баримт материалууд

Ес. Компанийг өөрчлөн байгуулах татан буулгах, өр төлбөрийг барагдуулах

1. Компаний өөрчлөн байгуулах тухай ойлголтод компанийг хуваах бусад компанитай нийлэх, нэгдэх, тусгаарлах, өөрчлөх асуудлууд хамаарагдана.
2. Компанийг өөрчлөн байгуулах асуудлыг "Компаний тухай хуулийн 18-24 дүгээр зүйлийн заалтуудыг үндэслэнэ.
3. Компани нь дараахь үндэслэлээр татан буугдана.
 - Төлбөрийн чадваргүй болж шүүхийн шийдвэрээр дампуурсан

- Үүсгэн байгуулагчийн шийдвэрээр цаашид үйл ажиллагаа явуулахгүй гэсэн
 - Хуульд заасан бусад үндэслэлүүдээр
4. Компанийг татан буутгах шийдвэр гаргасан байгууллагаас татан буулгах комиссыг томилон ажиллуулна.
 5. Татан буулгах комисс томилсноор тухайн компаний бүрэн эрх дуусгавар болж татан буулгах комисст шилжинэ.
 6. Татан буулгах комисс нь "Компаний тухай" хуулийн 26-29 дүгээр зүйлд заасны дагуу ажиллан, эцэст нь улсын бүртгэлээс компанийг хасуулж, ажлаа дуусгавар болгоно
 7. Татан буулгах комисс үүргээ гүйцэтгэх үедээ өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас тухайн компанид ямар нэгэн хохирол учруулсан бол уул хохиролыг хуульд заасан журмын дагуу хариуцна

Арав. Дүрэм хүчин төгөлдөр болох

1. Энэхүү дүрмийг монгол хэлээр тус бүр 4 хувь үйлдэж наториатаар гэрчлүүлэн нэг хувийг наториатад, нэг хувийг Улсын бүртгэлийн албанд, нэг хувийг компаний үүсгэн байгуулагчийг төлөөлөх Нийслэлийн Өмчийн Газарт, нэг хувийг компани өөртөө хадгална.
2. Энэхүү дүрэм нь компани улсын бүртгэлд бүртгэгдэж гэрчилгээ авсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.